



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, нийт 3,190,000.00 (гурван сая нэг зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, цагдаагийн хурандаа Д.Ядамдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Худалдсан автомашиныг Улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтын хамт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001285



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн  
8 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН

| Д/д | Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Нийт гүйлт (км) | Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | ТӨБЗГ-ын 2020 оны 582 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг)     |
|-----|-----------------------------------------------------------|-----------------------------------|-----------------|---------------------------------------------------|---------------------------------------------------------------------|--------------------------------|
| 1   | Хьюндай старекс, 55-02 УББ (арал-KMJWWH7BPWU059561)       | 1998                              | 215980          | 3,190,000.00                                      | 1,000,000.00                                                        | 500,000.00                     |
|     | Нийт дүн                                                  |                                   |                 |                                                   | 1,000,000.00 (нэг сая)                                              | 500,000.00 (таван зуун мянган) |